



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 11 сарын 23 өдөр

Дугаар 1/98

Баян-Өндөр сум

Г Журам батлах тухай Г

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67.5 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.19 дахь заалт, Химиин хорт болон аюултай бодисын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын "Химиин бодисын хордлогыг тандах мэдээлэх журам" 2013 оны А/467 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Химиин бодисын хордлогыг тандах, мэдээлэх журмыг нэгдүгээр, химиин бодисын хордлогын байнгын тандалтыг мэдээлэх маягтыг хоёрдугаар, байнгын тандалт тохиолдол, дэгдэлтийн үеийн мэдээлэл дамжуулах сүлжээг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Тушаалыг мөрдөж ажиллахыг Бүсийн оношилгоо эмчилгээний төв, сум, өрхийн эрүүл мэндийн төв, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын захирал, дарга наарт үүрэг болгосугай.
3. Энэхүү журмыг хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулж тушаалын хэрэгжилтийг ханган ажиллахыг Орчны эрүүл мэнд, нөлөөллийн үнэлгээ хариуцсан мэргэжилтэн (Н.Мөнгөнцацралт)-д даалгасугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн төвийн ахлах мэргэжилтэн (А.Ганчимэг)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.СҮХЭЭ



Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны // сарын 13-ны өдрийн
тушаалын нэгдүгээр хавсралт

9043446 2020030036

Химиин бодисын хордлогыг тандах, мэдээлэх журам

Нийтлэг үндэслэл: Химиин бодисын хордлогыг (ХБХ) тандах, бүртгэх, мэдээлэх тогтолцоог сайжруулах, хордлогоос урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

Зохион байгуулалтын арга хэмжээ:

1. ХБХ-ын өвчлөл болон химиин бодисын импорт, хэрэглээ, устгалын тухай холбогдох мэдээллүүдийг нэгтгэх, мэдээлэх үйл ажиллагааг Нийгмийн эрүүл мэндийн төв аймгийн түвшинд хариуцна.
2. "Химиин хорт бодис болон аюултай бодисын хууль"-ийн 7.2-д заасны дагуу төрийн захиргааны төв болон холбогдох байгууллагуудын салбарын чиг үүрэгтэй уялдсан химиин хорт болон аюултай бодисын мэдээллийн нэгдсэн сангаас химиин бодисын бүртгэл, импорт, хэрэглээ, устгалыг үйл ажиллагааны тухай мэдээллийг Нийгмийн эрүүл мэндийн төв нэгтгэн авч, тандалтын үйл ажиллагаанд ашиглана.
3. ХБХ-ын тандалтын үйл ажиллагааг ЭМГ хариуцан гүйцэтгэж, мал эмнэлэг, онцгой байдлын газраас ирүүлсэн мэдээллийг цуглуулна.
4. ХБХ-оос урьдчилан сэргийлэх, тандах, мэдээлэх, хордлогын эсрэг эрт сээрэмжлүүлэх, урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээг Нийгмийн эрүүл мэндийн төв хариуцан гүйцэтгэж, холбогдох мэргэжлийн байгууллагуудад хэрэгжүүлнэ.
5. ХБХ-д хамаарах үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг "Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм"-ийн дагуу бүртгэж мэдээлнэ.
6. ХБХ-д хамаарах Хүнсний химиин хордлогыг "Хоол хүнсээр дамжих өвчний тандах, хянах журам"-ын дагуу мэдээлж бүртгэнэ.
7. ХБХ-ын тандалтыг байнгын болон тохиолдол дэгдэлтийн үеийн гэсэн 2 хэлбэрээр зохион байгуулна.

Тандалт, мэдээллийн үйл ажиллагааны арга хэмжээ:

1. "Байнгын тандалт" гэж үйл ажиллагаа нь тасралтгүй үргэлжлэх тандалтыг хэлнэ.
2. Байнгын тандалтыг уг журмын Хавсралт 3.1-д заасан байнгын тандалтын мэдээллийн сүлжээний дагуу хийж гүйцэтгэх бөгөөд энэ нь химиин бодисын эрсдэлийн үнэлгээг хийж эрсдэлийг эрт илрүүлэх, сээрэмжлүүлэх, хордлого гарах нөхцөл боломжийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангахад чиглэгдэнэ.
3. ХБХ-ын байнгын тандалтын мэдээллийг тус тушаалын хавсралт 2-ын маягт 1-ын дагуу улирал бүрийн тайланг дараа сарын 10-ны өдрийн дотор ЭМГ-т ирүүлнэ.
4. "Тохиолдол-дэгдэлтийн үеийн тандалт" гэж ХБХ-ын тухайн тохиолдол, дэгдэлтийг үед хордлогын эх үүсвэр, шалтгаан, хамрах хүрээ, нөлөөлөх

- хүчин зүйлс, дамжих замыг тодруулж, эрт сээрэмжлүүлэх, таслан зогсоох хариу арга хэмжээг авах үйл ажиллагааг хэлнэ.
5. Тохиолдол-Дэгдэлтийн үеийн тандалт мэдээллийг ХБХ-ын тухай тохиолдол, дэгдэлтийн үед хордлогын эх үүсвэр, шалтгаан, хамрах хүрээ, нөлөөлөх хүчин зүйлс, дамжих замыг тодруулж, эрт сээрэмжлүүлэх, таслан зогсоох, хариу арга хэмжээ авахад ашиглана.
 6. ХБХ-ын тохиолдлын тандалтын мэдээг эрүүл мэндийн байгууллагууд тус тушаалын хавсралт 2-ын маягт 2-ын дагуу тухай бүрт нь онцгой байдлын газар, эрүүл мэндийн газарт уг журмын Хавсралт 3.2-т заасан тохиолдлын тандалтын мэдээллийн сүлжээний дагуу мэдээллэнэ.
 7. ХБХ-ын тохиолдлыг анх оношилсон эрүүл мэндийн байгууллагын ажилтан нь ЭМГ, ОБГ, цагдаагийн байгууллагад холбооны хэрэгсэл ашиглан (утас, электрон шуудан) яаралтай мэдээллэнэ.
 8. ХБХ-ыг анх оношилсон эмч голомтод хордлого тайлах анхны арга хэмжээг авч, тархвар судлалын анхан шатны судалгаа хийнэ.
 9. ЭМГ-ын Орчны эрүүл мэнд, нөлөөллийн үнэлгээ хариуцсан мэргэжилтэн тохиолдол бүрийг бүртгэж, байгууллагын дарга, тархвар судлагч нарт яаралтай мэдээллэнэ.
 10. Тархвар судлагч эмч тандалтын анхан шатны нэгжээс ирүүлсэн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, хордлогын тохиолдлын тоо, босго үзүүлэлтэд хүрсэн (нэг голомтод 2 ба түүнээс дээш тохиолдол гарсан, аюултай химиин бодисын хордлого илэрсэн, хүн нас барсан) тохиолдолд химиийн бодисын хордлогын үед дагаж мөрдөх, тандалтын стандарт, тушаал, заавар, журмын дагуу хариу арга хэмжээг зохион байгуулна.
 11. ХБХ-ын тохиолдол дэгдэлтийн үед ЭМГазар бусад холбогдох байгууллагуудтай хамтран хордлогын голомтод тархвар судлалын тандалт, судалгаа хяналтыг зохион байгуулж, эрүүл зүйн ба эмнэлзүйн хамтарсан дүгнэлт гаргана. Хордлогын тохиолдлыг мал амьтны гаралтай ёвчин, пестицид, малын эмийн буруу хэрэглээ, тариалалтын явц, хүнсний үйлдвэрлэл, түгээлт, импортын хүнсний бүтээгдэхүүнтэй холбоотой гэж үзсэн тохиолдолд хөдөө аж ахуйн газарт мэдэгдэж шаардлагатай хариу арга хэмжээг зохион байгуулна.
 12. ХБХ-ын байнгын болон тохиолдол тандалтын мэдээллийн дагуу харьяа СӨЭМТ-үүдээс химиийн хордлогод өртсөн үйлчлүүлэгчийг эргэн хянах, эрүүл мэндийн мэдээ мэдээллээр тасралтгүй хангаж ажиллана.

Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны 11 сарын 03-ны өдрийн
11 тушаалтын хоёрдугаар хавсралт

Химиин бодисын хордлогыг мэдээлэх маяг №2.1

9043446 2020030036

Мэдээг нэгтгэсэн: овог..... нэр

Албан тушаал:.....

Холбоо барих утас:.....

Химийн бодисын хордлогыг мэдээлэх маяг №2.2

Угаарын хийн хордлогын улмаас эмнэлгийн тусламж, үйлчилгээ авсан үйлчлүүлэгчийн мэдээлэл



Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны // сарын 12-ны өдрийн // тушаалын хөөрдугаар хавсралт

ХИМНИЙ БОДСЫН ХОРДЛОГЫГ МЭДЭЭЛЭХ МАЯГТ №23

Хүннүүдийн болон Хүчинчийн хорлогын улмаас эмнэлгийн туслаамж, үйлчилгээ авсан Үйлчилгээний Мэдээлэлийн

Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны 11. сарын 28-ны өдрийн
тушаалын гуравдугаар хавсралт

**ОРХОН АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ХИМИЙН БОДИСЫН
БАЙНГЫН ТАНДАЛТЫН МЭДЭЭЛЛИЙН СУЛЖЭЭ**



Хавсралт 3.2

**ОРХОН АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ХИМИЙН БОДИСЫН
ТОХИОЛДОЛЫН ТАНДАЛТЫН СУЛЖЭЭ**

